



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийслэлийн Багануур дүүргийн Энэрэлт өлзий ӨЭМТ-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: НТАГ-2026/211/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас: www.audit.mn
Улаанбаатар хот
2026 он

Нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга: Г.Нандинжаргал
Утас: 7000-7734 Цахим хаяг: nandinjargal@audit.gov.mn
Санхүүгийн аудитын албаны ахлах менежер: Х.Түвшинбаяр
Утас: 11315558 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn
Санхүүгийн аудитын албаны аудитын менежер: С.Гантөгс
Утас: 11315558 Цахим хаяг: gantugss@audit.gov.mn
Авера аудит ХХК-ийн гүйцэтгэх захирал: Г.Нарантуяа
Утас: 99133545 Цахим хаяг: avera.audit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

- 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ
- 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ГҮЙЦЭТГЭЛ
3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ
4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НА	Нотлох ажил
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ӨЭМТ	Өрхийн эрүүл мэндийн төв
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан
ЭМДЕГ	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар
НЭМГ	Нийслэлийн эрүүл мэндийн газар
НӨХГ	Нийслэлийн өмчийн харилцааны газар
ЭМДҮЗ	Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас:7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2026.03.13 № 695
танай _____ -ны № _____ -т

БАГАНУУР ДҮҮРГИЙН ЭНЭРЭЛТ
ӨЛЗИЙ ӨЭМТ-ИЙН
ДАРГА Т.ЭНЭРЭЛТ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4, 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.2, 8.4, Төсвийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.6-д заасны дагуу Нийслэлийн Багануур дүүргийн Энэрэлт өлзий ӨЭМТ-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ

Нийслэлийн Багануур дүүргийн Энэрэлт өлзий ӨЭМТ-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Нийслэлийн Багануур дүүргийн Энэрэлт өлзий ӨЭМТ нь Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газартай сэргээн засах үйлчилгээ, гэрээр үзүүлэх тусламж үйлчилгээ, оношилгоо шинжилгээ, өдрийн эмчилгээ гэсэн 4 төрлийн тусламж үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулан гүйцэтгэлээр Эрүүл мэндийн даатгалын сангаас 538.6 сая төгрөгийн санхүүжилт авч орлогын эх үүсвэр бүрдүүлэн ажилласан байна.

Аудитын гол асуудал

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хяналт, санхүүжилт, төлбөр тооцооны программ, цахим системийг бодит цагийн горимд шилжүүлж, иргэнд чанартай эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чирэгдэлгүй үзүүлж, гүйцэтгэлд суурилсан санхүүжилтээр үйл ажиллагаагаа явуулах эрх зүйн шинэчлэл хийгдсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Нийслэлийн Багануур дүүргийн Энэрэлт өлзий ӨЭМТ-ийн даргын 2025 оны А/01 дүгээр тушаалаар бүтэц орон тоог 15-аар баталж, тайлант онд бүрэн орон тоогоор үйл ажиллагаагаа явуулсан байна.

C:\Users\aranguus\Documents\Бичиг хэргийн 2026\20260313\Тайлан\Тайлан_20260313.docx 1426050593

Тус ӨЭМТ-ийн 2025 оны гүйцэтгэлийн гэрээний биелэлтийг Нийслэлийн Засаг даргын 2026 оны А/47 дугаар захирамжаар 87.7 хувь, ЭМДЕГ-аас эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ худалдан авах гэрээний биелэлт 89.8 хувийн хэрэгжилттэй гэж үнэлсэн байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Г.НАНДИНЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2025.01.01.	2025.12.31.
1	<u>ХӨРӨНГӨ</u>		
1.1.1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	16,484,341.33	46,950.74
1.1.2	Дансны авлага	239,157.45	239,157.44
1.1.4	Бусад авлага	17,081,383.88	6,810,996.40
1.1.6	Бараа материал	24,635,617.20	15,168,174.40
1.1	Эргэлтийн хөрөнгийн дүн	58,440,499.86	22,265,278.98
1.2.1	Үндсэн хөрөнгө (цэвэр)	86,695,972.08	79,892,678.42
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	86,695,972.08	79,892,678.42
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	145,136,471.94	102,157,957.40
2.1.1	<u>Богино хугацаат өр төлбөр</u>	-	11,415,454.20
2.1.1.1	Дансны өглөг		3,130,000.00
2.1.1.3	Татварын өглөг		8,285,454.20
2.2	Нийт өр төлбөр	-	11,415,454.20
2.3	<u>Эзэмшигчдийн өмч :</u>		
2.3.1	Өмч-төрийн	89,625,300.00	89,625,300.00
2.3.2	-хувийн	675,000.00	675,000.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	1,555,000.00	1,555,000.00
2.3.9	Хуримтлагдсан үр дүн	53,281,171.93	53,281,180.86
2.3.10	Тайлант үеийн		(54,393,977.66)
2.3.11	Эзэмшигчдийн өмчийн дүн	145,136,471.93	90,742,503.20
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧИЙН ДҮН	145,136,471.93	102,157,957.40

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2025.01.01.	2025.12.31.
1	Борлуулалтын орлого	524,699,568.06	538,614,181.70
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг		
3	Нийт ашиг	524,699,568.06	538,614,181.70
5	Хүүний орлого	93,048.44	68,372.93
8	Бусад орлого	96,908,616.00	21,320,089.30
9	Борлуулалт, маркетингийн зардал		
10	Ерөнхий удирдлагын зардал	593,347,645.06	603,325,421.35
11	Санхүүгийн зардал	57,900.00	66,300.00
12	Бусад зардал	17,050,000.00	10,692,150.00
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(246,583.33)	(312,750.24)
18	Татварын өмнөх ашиг (алдагдал)	10,999,104.11	(54,393,977.66)
19	Орлогын албан татварын зардал		
20	Тайлант жилийн татварын дараах ашиг (алдагдал)	10,999,104.11	(54,393,977.66)
24	Орлогын нийт дүн	621,701,232.50	560,002,643.93

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2025.01.01.	2025.12.31.
1.1	1.1 Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлого	604,913,410.18	564,629,632.18
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсэн орлого	122,117,693.38	95,045,750.00
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	159,523.00	547,306.00
	Татаас санхүүжилтийн орлого	462,940,190.80	453,837,419.18
	Бусад орлого	19,696,003.00	15,199,157.00
1.2	1.2 Үндсэн үйл ажиллагааны мөнгөн зарлага	578,408,697.78	563,635,395.70
	Ажиллагсад төлсөн мөнгө	364,552,595.00	359,654,388.00
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	94,017,176.73	97,904,967.32
	Бараа материал худалдан авахад төлсөн	32,930,325.00	32,568,330.00
	Ашиглалтын зардалд төлсөн мөнгө	24,349,519.05	8,415,277.20
	Түлш шатахуун, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө	3,282,129.00	1,472,400.00
	Татварын байгууллагад төлсөн	37,470,131.00	29,452,198.87
	Даатгалын төлбөрт төлсөн мөнгө	-	346,920.00
	Бусад мөнгөн зарлага	21,806,822.00	33,820,914.31
1.3	Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	26,504,712.40	994,236.48
2	2.Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	2.1 Мөнгөн орлогын дүн	93,048.44	68,372.93
	Хүлээн авсан хүүний орлого	93,048.44	68,372.93
2.2	2.2 Мөнгөн зарлагын дүн	10,450,000.00	17,500,000.00
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн мөнгө	10,450,000.00	17,500,000.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(10,356,951.56)	(17,431,627.07)
3	3.Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	3.1 Мөнгөн орлогын дүн	-	7,000,000.00
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	7,000,000.00

Нийслэлийн Багануур дүүргийн Энэрэлт өлзий ӨЭМТ-ийн 2025 оны
санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

3.2	3.2 Мөнгөн зарлагын дүн	-	7,000,000.00
	Зээл,өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн		7,000,000.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	-	-
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	16,147,760.84	(16,437,390.59)
6	<i>Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</i>	336,580.49	16,484,341.33
7	<i>Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</i>	16,484,341.33	46,950.74

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	Нийт
1	2024 оны 01-р сарын 01-ээрх үлдэгдэл	89,625,300.00	1,555,000.00	675,000.00	42,282,067.82	134,137,367.82
2	Бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдаа					-
3	Залруулагдсан үлдэгдэл	89,625,300.00	1,555,000.00		42,282,067.82	134,137,367.82
4	Тайлант хугацааны цэвэр ашиг (алдагдал)	-			10,999,104.11	10,999,104.11
8	2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	89,625,300.00	1,555,000.00	-	53,281,171.93	145,136,471.93
9	Бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдаа	-			8.93	8.93
10	Залруулагдсан үлдэгдэл	89,625,300.00	1,555,000.00	-	53,281,180.86	145,136,480.86
12	Тайлант хугацааны цэвэр ашиг (алдагдал)	-			(54,393,977.66)	(54,393,977.66)
15	2025 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	89,625,300.00	1,555,000.00	-	(1,112,796.80)	90,742,503.20

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой нийт 102,263.4 мянган төгрөгийн 2 алдаа¹ илэрснийг аудитын явцад залруулга хийлгэж баталгаажуулсан. Үүнд:

- Орлогын дэлгэрэнгүй тайланд 85,183.4 мянган төгрөгийн орлогыг ангилал зөрүүтэй тайлагнасан;
- Мөнгөн гүйлгээний тайлан 17,079.9 мянган төгрөгийн орлогыг ангилал зөрүүтэй тайлагнасан зэрэг алдааг залруулав.

Энэ нь НББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга, MNS-6817-4:2020 стандартын 5.2.1.7.2 “Иж бүрэн байх-санхүүгийн тайланд өгөх дүгнэлтэд нөлөөлж болзошгүй гүйлгээ, үйл явдал, дансны үлдэгдэл, тодруулгыг орхигдуулалгүй тусгасан байх” болон санхүүгийн тайлагналын “*толилуулга ба тодруулга*”, “ангилал” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 5,985.1 мянган төгрөгийн зөрчил² илэрсэнд 3 зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй 5,985.1 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага тул “Зөрчилгүй” дүгнэлт өглөө.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт-1: Байгууллагын үйл ажиллагаанд ашиглаж буй элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн, үлдэгдэл өртөггүй болсон (24,569.5 мянган төгрөг) хөрөнгийн ашиглалтын хугацааг тухайн хөрөнгийн эдийн засгийн нас буюу эдийн засгийн өгөөжид үндэслэн тогтоож дахин үнэлээгүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 2-т “*илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох;*” гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын “толилуулга ба тодруулга”, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Элэгдлээрээ анхны өртгөө нөхөж үлдэх өртөггүй болсон хөрөнгийг дахин үнэлэх хүсэлтийг холбогдох байгууллагад хүргүүлж шийдвэрлүүлэх зөвлөмж өгөв.

Илрүүлэлт 2: Дүүргийн Эрүүл мэндийн төвд 4,580.0 мянган төгрөгийн хөрөнгийг ашиглуулж байна. Энэ нь Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/320 тушаалаар баталсан “Өрхийн эрүүл мэндийн төвийн дүрэм”-ын 7.3-т “Төв нь төрийн болон орон

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

нутгийн өмч,хөрөнгийг холбогдох байгууллагын зөвшөөрөлгүйгээр гуравдагч этгээдийн эзэмшил, ашиглалтад шилжүүлэхийг хориглоно” гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Дүүргийн Эрүүл мэндийн төвд ашиглуулж байгаа хөрөнгийг буцаан авах зөвлөмж өгөв.

2.Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт 1: Ээлжийн амралтын тушаалд амрах хоногийг буруу оруулснаас 2 хүнд 1,313.3 мянган төгрөгийг дутуу, 1 хүнд 91.7 мянган төгрөгийг илүү олголт үүссэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 3.1-т “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.”20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын “толилуулга ба тодруулга”, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Ээлжийн амралтын тушаалд амралтын хоногийг зөв оруулж, ээлжийн амралтын олговрыг үнэн зөв тооцож олгох зөвлөмж өгөв.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
							Залруулсан		Залруулаагүй	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Орлогын дэлгэрэнгүй тайланд 85,183.4 мянган төгрөгийн орлогыг ангилал зөрүүтэй тайлагнасан.	1	85,183.4			1	85,183.4	1	85,183.4		
Мөнгөн гүйлгээний тайланд 17,079.9 мянган төгрөгийн орлогыг ангилал зөрүүтэй тайлагнасан	1	17,080.0			1	17,080.0	1	17,080.0		
Дүн	2	102,263.4	0	-	2	102,263.4	2	102,263.4	0	0

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо
Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн, үлдэгдэл өртөггүй болсон (24,569.5 мянган төгрөг) хөрөнгийг дахин үнэлээгүй байна.	1	-					1	-		
Ээлжийн амралтын тушаалд амрах хоногийг буруу оруулснаас 2 хүнд 1,313.3 мянган төгрөгийг дутуу, 1 хүнд 91.7 мянган төгрөгийг илүү олгосон байна.	1	1,405.1					1	1,405.1		
Дүүргийн Эрүүл мэндийн төвд 4,580.0 мянган төгрөгийн хөрөнгийг ашиглуулж байгаад зөвлөмж өгсөн нь хэрэгжээгүй байна.	1	4,580.0					1	4,580.0		
Дүн	3	5,985.1	-	-	-	-	3	5,985.1		